



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/204

Арвайхээр

Сарын аян зохион байгуулах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны 2015 оны 4 дүгээр тогтоолоор батлагдсан Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн дүрмийн 2.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ-2020” хөтөлбөрийн 3.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг 2019 оны 4 дүгээр сарын 1-ээс 5 дугаар сарын 1-ний хооронд аймгийн хэмжээнд зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, сарын аяны төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сарын аяныг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аймгийн салбар хорооны дарга (О.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3. Аяныг зохион байгуулахад зарцуулах 1780000 (нэг сая долоон зуун наян мянга) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100453

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН САРЫН АЯНЫ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг сурталчилах, иргэдийн мэдлэгийг сайжруулах, ажлын байран дахь хими, биологи, физикийн болон бусад хүчин зүйлсийн нөлөөллийн улмаас хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажил олгогч, ажилтны хүлээх үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг олгоход чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион явуулахад аяны зорилго оршино.

Хоёр. Хугацаа

2019 оны 4 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 1-ний өдрийг дуустал

Гурав. Хамтран зохион байгуулах байгууллага

- Аймгийн Засаг даргын Тамгын газар
- Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
- Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар
- Аймгийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн даатгалын хэлтэс
- Өвөрхангай аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
- Аймгийн Ажил олгогч эздийн холбоо
- Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо
- Сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл

Дөрөв. Зохион байгуулах арга хэмжээ

- Сарын аяны нээлт хийх
- Нийтийн хоол, дулаан үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад “Эрүүл аюулгүй ажлын байр” туг, цүнх аялуулах
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, журам, стандартын талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, зөвлөгөө мэдээлэл өгөх
- Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнуудыг оролцуулсан сургалт, семинар, ярилцлага, үзүүлэх сургууль зохион байгуулах
- Эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгож, ажилчдынхаа эрүүл мэнд, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн асуудалд анхаардаг тэргүүний байгууллага хамт олны ажлын арга туршлагыг дэлгэрүүлэх
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн асуудлаар үзлэг шалгалтыг хамтран хийх
- Сарын аяны үеэр хийж байгаа ажлынхаа талаар орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах
- “Дэвжээ” тэмцээн зохион байгуулах

Тав. Хамрах хүрээ

Ажил олгогч, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчид

Аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 22 ны өдрийн 14 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН САРЫН АЯНД ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ

№	Хийгдэх ажил	Шаардагдах материал	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян" шторк бэлтгэх	Шторк бэлтгэх	1	100.000	100.000
2	"Эрүүл, аюулгүй ажлын байр" аяны туг аялуулах	Туг хийлгэх	2	90.000	180.000
3	Төв гудамжид сарын аяны анонс байрлуулах	Анонс хийлгэх	2	180.000	360.000
4	Сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл, ахуйн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах	Хоолны зардал	60	13.000	780.000
5	Нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагууды дунд "Дэвжээ" тэмцээн зохион байгуулах	1 дүгээр байр	1	150.000	150.000
		жааз, өргөмжлөл	1	10.000	10.000
		2 дугаар байр	1	100.000	100.000
		жааз, өргөмжлөл	1	10.000	10.000
		3 дугаар байр	1	80.000	80.000
		жааз, өргөмжлөл	1	10.000	10.000
НИЙТ ДҮН					1 780 000